



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/154

Арвайхээр

### Зардал хуваарилах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.а, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны “Зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эрх шилжүүлэх тухай” А/42 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XV.1.6 дугаарт батлагдсан Багийн төвийн мал угаалгын банн, талбай /Өвөрхангай, Бат-Өлзий, Хархорин, Хужирт, Уянга, Зүүнбаян-Улаан сум/-д зарцуулах 300.000.000 (гурван зуун сая) төгрөгийн зардлыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтад тусгагдсан хөтөлбөр арга хэмжээг худалдан авах ажиллагааны дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100331

Аймгийн Засаг даргын 2020 оны 04  
дугаар сарын 13-ны өдрийн 1154 дугаар  
захирамжийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН  
2 ДУГААР ХАВСРАЛТЫН XV.1.6 ДУГААРТ БАТЛАГДСАН БАГИЙН  
ТӨВИЙН МАЛ УГААЛГЫН БАНН, ТАЛБАЙ /ӨВӨРХАНГАЙ,  
БАТ-ӨЛЗИЙ, ХАРХОРИН, ХУЖИРТ, УЯНГА, ЗҮҮНБАЯН-УЛААН  
СУМ/-Д ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ

№	Төсөл хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /мян төг/
1.	Багийн төвийн мал угаалгын банн, талбай /Бат-Өлзий сум 3, Зүүнбаян-Улаан сум 5/	120 000.0
2.	Багийн төвийн мал угаалгын банн, талбай /Хархорин сум 2, Хужирт сум-4/	90 000.0
3.	Багийн төвийн мал угаалгын банн, талбай /Уянга сум 6/	90 000.0
	НИЙТ ДҮН	300 000.0

-oOo-